



ХӨВСГӨЛ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР
“Хөвсгөл аймгийн 2014 оны орон нутгийн төсвийн
гүйцэтгэл” гүйцэтгэлийн аудитын тайлан
ҮАГ- ГАГ/2015/04-ГА-ХөААГ

УИХ-ын Төсвийн Байнгын хорооны 2014 оны 20 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан.



Орон нутгийн төсвийн гүйцэтгэлд шинжилгээ хийж төсвийн үр ашгийг тооцохгүй байна.

2015 оны 5 дугаар сар



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬАА
ХӨВСГӨЛ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ**

2015 оны 05 сарын 12 өдөр

Дугаар 5/19

Мөрөн

Аудитын тайлан баталгаажуулах тухай

УИХ-ын төсвийн байнгын хорооны 2014 оны 20 дугаар тогтоол, МУ-ын Ерөнхий аудитормын 2014 оны 121, Аймгийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитормын 2015 оны 04 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Хөвсгөл аймгийн 2014 оны орон нутгийн төсвийн гүйцэтгэл"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Гүйцэтгэлийн аудитын тайланг Үндэсний аудитын газар, аймгийн Засаг дарга, аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтэст тус тус хүргүүлсүгэй.
3. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллан үр дүнг 2015 оны 10 дугаар сарын 1-ний дотор багтаан аймгийн Аудитын газарт ирүүлэхийг аймгийн Засаг дарга А.Эрдэнэбаатар, аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга Г.Сувд нарт зөвлөсүгэй.
4. Зөвлөмжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Аудитын менежер Г.Эрдэнэчимэг, ахлах аудитор Л.Энх-Амгалан нарт даалгасугай.

АЙМГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ОЮУНГЭРЭЛ

070031

6/12, тоот тушаалын хавсралт.

“Хөвсгөл аймгийн 2014 оны орон нутгийн төсвийн гүйцэтгэл”-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар илрүүлсэн зөрчил

№	Зөрчлийн товч утга	Илрүүлсэн зөрчил /сая төгрөгөөр/
1	Аймгийн засаг даргын 2014 оны 12 дугаар сарын 24-ний А/461 тоот захирамжаар Халамжийн сангийн зардалд 20,9 сая төгрөгийн, улсын төсвөөс санхүүжих санхүүгийн дэмжлэгийг 20,9 сая төгрөгөөр бууруулан өөрчлөлт хийсэн нь Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.2 заалтыг зөрчсөн байна.	20.9
	Дүн	20.9

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн: ААГ-ын Гүйцэтгэлийн аудитын баг Тэргүүлэх аудитор: Г.Оюунгэрэл Утас: 96665871 Аудитын менежер: Г.Эрдэнэчимэг Утас: 99016320 Ахлах аудитор: Л. Энх-Амгалан Утас: 96383478 Аудитор: Л.Магсаржалам Утас: 99100499 2015 оны 05 дугаар сар Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70384043 дугаарын утас, 70383793 дугаарын факсаар харилцана уу? ХАЯГ: (Хөвсгөл аймгийн ЗДТГ-ын А байр)	Товчилсон үг Аудитын зорилт, хамрах хүрээ, арга зүй Бүлэг 1. Орон нутгийн төсвийн орлого, зарлагын төлөвлөлтийн үндэслэл Бүлэг 2. Орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэл Бүлэг 3.Орон нутгийн зарлагын гүйцэтгэл Дүгнэлт: Зөвлөмж: Албан шаардлага: Холбогдох байгууллагын санал: Саналд өгөх тайлбар:
--	---

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

МУ	Монгол улс
УИХ	Улсын их хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
ААГ	Аймгийн аудитын газар
ЗГ	Засгийн газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
АЗДТГ	Аймгийн засаг даргын тамгын газар
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
БЗД	Багийн засаг дарга
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНӨА	Орон нутгийн өмчийн алба
ГХБХБГазар	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
ХГБХХэлтэс	Хүүхэд, гэр бүл, хөгжлийн хэлтэс
БОГазар	Байгаль орчны газар
ХДТ	Хөгжимт драмын театр
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ОНӨААҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн газар
ХХАОТ	Хүн амын орлогын албан татвар
ОТБТБАҮХИ	Орлогыг тодорхойлох боломжгүй татвар төлөгч иргэн
АТБӨЯХАТ	Автотээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар
БОНХЯ	Байгаль орчин, ногоон хөгжлийн яам
ТТАМАТ	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр
ШШГА	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба
ААН	Аж ахуйн нэгж
АТЕЗ	Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Аудитыг Төсвийн тухай хуулийн 8.10.2-т заасны дагуу, Монгол улсын ерөнхий аудиторт Үндэсний аудитын газраас 2015 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Хөвсгөл аймгийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Хөвсгөл аймгийн 2014 оны орон нутгийн төсвийн гүйцэтгэлд аудитийг хийлээ.

Аудитын зорилт

Хөвсгөл аймгийн 2014 оны орон нутгийн төсвийн гүйцэтгэл үнэн зөв илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт гарган УИХ-д болон аймгийн ИТХ, аймгийн Засаг даргад танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ.

Үүнд:

- Орон нутгийн төсвийн орлого, зарлагын төлөвлөлтийн үндэслэл
- Орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэл
- Орон нутгийн төсвийн зарлагын гүйцэтгэл

Хамарсан хүрээ

Хөвсгөл аймгийн 2014 оны орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэл болон зарлагын гүйцэтгэлийн тайлан, судалгаа, мэдээлэл болон холбогдох бусад баримт материалд тулгуурлан аудитыг гүйцэтгэв.

Санхүү, төрийн сангийн хэлтэс Төсвийн тухай хуулийн 14.2.6-д заасны дагуу Хөвсгөл аймгийн 2014 оны орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн танилцуулгыг дараах байдлаар бэлтгэн тайлагнажээ.

Сангийн сайдын 2009 оны 171 дүгээр тушаалаар баталсан “Улс, орон нутгийн төсвийн нягтлан бодох бүртгэлийн бодлого”-ын 1.3-д “Улс, орон нутгийн төсвийн орлого, зарлагыг мөнгөн суурьтай бүртгэлийн зарчмаар хүлээн зөвшөөрч тайлагнана” гэж заасны дагуу АЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс Хөвсгөл аймгийн 2014 оны орон нутгийн төсвийн гүйцэтгэлийг мөнгөн сууриар тооцож тайлагнасан байна.

Аудит хийх багийн бүрэлдэхүүн

Аудитыг Үндэсний аудитын газрын харьяа Хөвсгөл аймгийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Г.Оюунгэрэл удирдан, аудитын менежер Г.Эрдэнэчимэг аудитын арга зүйгээр хангаж, үе шатны болон чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Л.Энх-Амгалан, аудитор Л.Магсаржалам нар гүйцэтгэв.

Арга зүй, стандартын талаарх мэдэгдэл

Аудитыг гүйцэтгэхдээ аудитын олон улсын стандарт, санхүүгийн аудитын гарын авлага, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийг мөрдлөг болгосны зэрэгцээ холбогдох байгууллагын албан тушаалтнуудтай ярилцлага хийх, судалгаа авах, дансны хуулгатай тулган баталгаажуулах, тоон мэдээлэл авах, дүн дүгнэлтэд үндэслэн зөвлөмжийг боловсруулав.

Хөвсгөл аймгийн 2014 оны орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг боловсруулахдаа төсвөөс санхүүжигдэх үйл ажиллагааг хэвийн явуулах эх үүсвэрийг бүрдүүлэхэд чиглэгджээ.

Үндсэн мэдээлэл:

✚ Хөвсгөл аймгийн 2014 оны орон нутгийн орлого, зарлагыг 2013 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдааны 07 дугаар тогтоолоор баталсан байна.

✚ Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдааны 2014 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор төсөвт тодотгол хийсэн байна.

Орон нутгийн төсвийн тодотголыг дараах нөхцлөөр хийсэн байна. Үүнд:

1. Улсын төсвийн тодотголын дагуу аймгийн төсөвт өөрчлөлт оруулах
2. Орон нутгийн төсвийн орлого нэмэгдүүлж ,орон нутгийн төсөвт дутагдаж байгаа зардлын эх үүсвэрийг бүрдүүлэх /Хүн амын орлогын албан татварын буцаан олголтыг нэмэгдүүлэх /
3. Монгол улсын төсвийн тухай хуулийн 57,3-т заасны дагуу ерөнхий орлогын дансанд төвлөрүүлсэн 2013 оны үлдэгдлийг зарцуулах
4. Монгол улсын Засгийн Газрын 2014 оны 04 дүгээр сарын 129-р тогтоол, Сангийн сайд хүн амын хөгжил нийгмийн хамгааллын сайдын 2014 оны 03 дугаар сарын 01/02 тоот албан даалгаврын хэрэгжилтийг хангаж Нийгмийн халамж, асрамж үйлчилгээний зардлын төсвийг аймаг, сумын төсөвт хуваарилах
5. Аймгийн аудитын газрын зөвлөмж албан шаардлагыг хэрэгжүүлэх зорилгоор төсвийн тодотголыг хийсэн байна.

Уг тодотголоор: УИХ-аас Монгол улсын 2014 оны төсөвт хийсэн тодотголтой холбогдуулан аймгийн орон нутгийн төсөв болон тусгай шилжүүлгийн төсөвт өөрчлөлт оруулсан байна. Үүнд:

- 1, ОНХС-ийн санхүүжилтийг 17823,0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэх
- 2, Орон нутгийн төсвийн байгууллагуудын цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаас 53019,0 мянган төгрөгийг хасах
- 3, Тусгай зориулалтын шилжүүлгийн зарим байгууллагуудын цалин нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаас 27379,4 мянган төгрөгийг хасах

4, Ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллага, сумын эрүүл мэндийн төвүүд, сумдын соёлын төвүүдийн төсөвт 1524153,4 мянган төгрөг, орон нутгийн байгууллагуудаас Хот тохижилт үйлчилгээний төв, Ахмад настны асрамж үйлчилгээний газрын төсөвт 7771,5 мянган төгрөгөөр цалин нийгмийн даатгалын шимтгэлийг нэмэгдүүлэх өөрчлөлт хийгдсэн.

ОНХС-ийн санхүүжилтийг 17823,0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж байгаа бөгөөд үүнийг журмын дагуу тухайн орон нутгийн хөгжлийн индекс, хүн амын тоо нягтаршил, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээг харгалзан Засгийн газрын 30-р тогтоолын дагуу хуваарилан тогтоолын төслийн 3 дугаар хавсралтад оруулсан бөгөөд хуваарийн дагуу аймаг болон сумдын санхүүжилтийг нэмэгдүүлсэн.

Хасах тодотголын тухайд: Орон нутгийн байгууллагуудаас аймаг, сумын ИТХурал /ОНӨА/, ЗДТГазар, сумдын БЗДарга, Ахмадын хороо, Сум дундын ойн анги, ХАААлба, БОГазар зэрэг байгууллагуудын зөвхөн цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаас 53019,0 мянган төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудаас Орон нутгийг судлах музей, Нийтийн номын сан, ХДТеатр, ГХБХБГазар, ХГБХХэлтэс зэрэг байгууллагуудын цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаас 27379,4 мянган төгрөгийг хасах тодотгол хийсэн байна.

Цалин, нийгмийн даатгалын шимтгэлийг нэмэгдүүлэх тодотголд тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудаас Ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллага, сумын эрүүл мэндийн төвүүд, сумдын соёлын төвүүдийн төсөвт **1 524 153,4** мянган төгрөг, орон нутгийн байгууллагуудаас Хот тохижилт үйлчилгээний төв, Ахмад настны асрамж үйлчилгээний газрын төсөвт 7771,5 мянган төгрөгийг нэмэгдүүлэх тодотгол хийсэн байна.

Монгол улсын засгийн газрын 2014 оны 75-р тогтоол, Монгол улсын 2014 оны төсөвт хийсэн тодотголоор аймгийн орон нутгийн төсөв болон тусгай шилжүүлгийн байгууллагуудын төсөв **1 469 349,5** мянган төгрөгөөр өөрчлөгдөж байгаа бөгөөд доорхи хүснэгтээр байгууллага бүрийн дүнг харууллаа.

/ мян.төг-өөр /

ДД	Байгууллага	Анх баталсан	Тодотгох дүн	Тодотгосон дүн
1	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	219,010.0	-805.5	218,204.5
2	Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	1,085,664.3	-10,815.5	1,074,848.8
3	Аймгийн Засаг даргын Тамгын газар	1,605,241.3	-3,779.2	1,601,462.1
4	Сумын Засаг даргын Тамгын газар	5,134,700.9	-18,410.9	5,116,290.0
5	Багийн Засаг дарга	1,359,578.9	-11,561.2	1,348,017.7
6	Хүүхдийн цэцэрлэг	9,983,987.9	328,352.0	10,312,339.9
7	Ерөнхий боловсролын сургууль	29,721,938.2	989,913.7	30,711,851.9
8	Сумын эмнэлэг	5,276,166.9	200,709.0	5,476,875.9
9	Ахмадын хороо	57,915.3	-213.2	57,702.1
10	Хот тохижуулах газар	698,205.3	5,758.2	703,963.5
11	Соёл, спорт, аялал жуулчлалын газар	393,177.1	237.5	393,414.6
12	Орон нутгийн музей	146,715.2	-320.0	146,395.2
13	Орон нутгийн номын сан	166,981.8	-330.4	166,651.4
14	Аймаг, хотын театр, чуулга	601,069.9	-2,566.9	598,503.0

15	Сумдын соёлын төв	1,232,698.4	4,941.2	1,237,639.6
16	Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар	298,859.7	-1,407.3	297,452.4
17	Ойн анги	193,362.7	-1,190.9	192,171.8
18	Орон нутгийн хүүхдийн байгууллага	255,162.0	-130.8	255,031.2
19	Өрхийн эмнэлэг	418,999.8	-22,624.0	396,375.8
20	Орон нутгийн Өмчийн алба	32,527.1	-259.4	32,267.7
21	Аймаг, нийслэлийн Худалдан авах ажиллагааны нэгж	56,435.3	-596.9	55,838.4
22	Аймгийн байгаль орчныг хамгаалах газар	626,765.3	-5,386.3	621,379.0
23	Аймгийн асрамжийн газар	348,120.4	2,013.3	350,133.7
24	Орон нутгийн хөгжлийн сан	12,840,612.9	17,823.0	12,858,435.9
25	Татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх замаар бий болсон нэмэлт эх үүсвэр	23,118.0	0.0	23,118.0
26	Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардал	580,441.6	0.0	580,441.6
27	Жолоочийн хариуцлагын даатгалын санд олгох шилжүүлэг	45,352.8	0.0	45,352.8
28	Аймгийн халамжийн сан	13,289,301.0	0.0	13,289,301.0
29	Орон нутгийн мал эмнэлгийн үйлчилгээ	505,217.2	0.0	505,217.2
30	Замын сан	408,175.3	0.0	408,175.3
31	Орон нутгийн төсвийн нөөц хөрөнгө	290,000.0	0.0	290,000.0
32	Ус сувгийн газар	526,252.0	0.0	526,252.0
АЙМГИЙН ДҮН		88,421,754.5	1,469,349.5	89,891,104.0

Аймгийн ИТХ-ын 2014 оны 6 дугаар сарын 01 тоот тогтоолоор орон нутгийн орлогыг 414100.0 мянган төгрөгөөр, дансны үлдэгдлээс санхүүжүүлэхээр 1175 529,0 мянган төгрөгөөр зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болгохоор баталсан байна.

Төсвийн урсгал зардалд хийсэн дээрх тодотголыг дараах эх үүсвэрээр санхүүжүүлэхээр баталсан байна. Үүнд:

мянган төгрөгөөр

Үзүүлэлт	2013 оны дансны үлдэгдэл	ОНО-т хийх тодотгол
Нийгмийн халамж үйлчилгээний зардал	1 016 384,0	
Нөөц сангийн үлдэгдэл	45 984,3	
Байгаль хамгаалах сангийн үлдэгдэл	45 000,0	
Замын сангийн үлдэгдэл	21 000,0	
Хэмнэлтэд тооцохгүй зардлын үлдэгдэл	47 160,0	
ЦХТАО-ын АТ		158 600,0
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар		100 000,0
Газрын төлбөрийн орлого		30 000,0
Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллаганы орлого		25 500,0

ОНӨҮГ-ын ногдол ашиг		100 000
ХАОАТ-ын буцаан олголт		-424 700,0
Нийт дүн	1 164 929,0	

Төсвийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45,2 заалтыг үндэслэн 2013 оны үлдэгдэл Нийгмийн халамж үйлчилгээний зардал, засаг даргын нөөц сан, замын сан болон орон нутгийн төсвийн байгууллагуудын төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлсэн 1175529,0 мянган төгрөгийг урсгал зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болгосон байна.

Харин Засгийн газрын 2014 оны 75-р тогтоолоор Боловсрол, эрүүл мэндийн байгууллагууд болон төрийн үйлчилгээний зарим ажилчдын цалин нэмэгдснийг үндэслэн цалин хөлс түүнтэй адилтгах орлогын албан татварыг 158,6 сая төгрөгөөр, Төсвийн тухай хуулийн 23,7,1-р заалт, Аймгийн ИТХ-ын тогтоолын дагуу “Хөвсгөл дулаан” орон нутгийн өмчит үйлдвэрийн газраас орон нутгийн өмчид ноогдох хувьцааны ногдол ашиг төлөхөөр шийдвэрлэсний дагуу Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн орон нутгийн өмчид ноогдох хувьцааны ногдол ашгийг 100,0 сая төгрөгөөр **нийт 1589,6** сая төгрөгөөр аймгийн орон нутгийн төсвийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлсэн байна.

Сумдын төрийн сангийн төлөөлөгч, татварын байцаагчдын ирүүлсэн тооцоолол, үл хөдлөх хөрөнгийн албан татвар, газрын төлбөрийн орлогыг тайлант жилийн гүйцэтгэл, суурь судалгаан дээр үндэслэн холбогдох мэргэжилтнүүдтэй санал солилцож **130.0** сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой гэж тооцсон байна.

Үүнд:

- 2013 оны байдлаар Үл хөдлөх хөрөнгийн татвар гүйцэтгэлээр 285,0 сая төгрөг болж төлөвлөгөөг 65.0 сая төгрөгөөр давуулсан, 2014 онд шинээр бий болох үл хөдлөх хөрөнгө болон, үл хөдлөх хөрөнгийн тооллогын үр дүн зэрэгт тулгуурлан үл хөдлөх хөрөнгийн албан татварыг нэмэгдүүлсэн байна. Энэ нь 2013 оны гүйцэтгэлээс 35,0 сая төгрөгөөр, оны эхэнд батлагдсан төлөвлөгөөнөөс 100,0 сая төгрөгөөр нэмэгдэж байгаа болно.

Зардлын тодотгол:

Зардалд хийсэн тодотголыг доорх хүснэгтээр харуулав.

№	Зардлын зориулалт	2014 онд санхүүжүүлэх хөрөнгийн дүн /мян төг/	ҮНДЭСЛЭЛ
1.Орон нутгийн төсвийн байгууллагуудын зарлага -304719,0			
1	Аймгийн ИТХ-ын дэргэдэх иргэний зөвлөлийн зардал	6000	Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн хуралдааны 2014 оны 15-р тогтоол
2	Аймгийн шагналын зардал /Аймгийн ИТХ/	11200,0	АИТХ-ын Тэргүүлэгчдийн 2009 оны 47-р тогтоол

3	Аймгийн ЗДТГ-ын архивын тасгийн архивч Долгорсүрэн албан үүргээ гүйцэтгэж яваад амь эрсдсэнтэй холбогдуулан ар гэрт үзүүлэх тэтгэмж /үндсэн цалингийн 36 сартай тэнцэх 17637.8 мянган төгрөг, Ажлын байран дээрээ бие нь муудаж нас барсан жижүүр Д.Сүхбаатарын ар гэрт 6 сарын тэтгэмж 2181.2 мянган төгрөг/	19,819.0	Хөдөлмөрийн хуулийн 97.1.3
4	Аймгийн ЗДТГ-ын Албан хаагчдын хэрэгцээнд дутагдаж буй техник хэрэгсэлд "Сүлд" танхимд авах техник хэрэгсэл 13800.0 мянган төгрөг, цалин НДШ, гадаад томилолт-13450.9 мянган төгрөг /Аймгийн ЗДТГ/	26050,0	Төрийн албаны тухай хуулийн 27.1.2
5	Төрийн албан хаагчдын сургалтын зардал	10000,0	Төрийн албаны тухай хуулийн 18.1.6 МУЗЗНДНТУ-ын тухай хуулийн 33.1.6
6	Хотгойд хурд-3 наадам, жалханз хутагт Дамдинбазарын мэндэлсний 140 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх зардал	105150,0	ЗГ-ын 2014 оны 28 дугаар тогтоол
7	Тосонцэнгэл сумын ЗДТГ, эмнэлэг сургууль хүүхдийн цэцэрлэгийг шилэн кабельд холбох	9,605.0	Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний 288, 103, 80, 88-р заалт Монгол Улсын засгийн газрын 2011 оны 125-р тогтоол "Өндөр хурдны өргөн зурвасын сүлжээ"
8	Их-Уул сумын ЗДТГ, эмнэлэг сургууль хүүхдийн цэцэрлэгийг шилэн кабельд холбох	9,216.0	
9	Цагаан-Үүр сумын ЗДТГ, эмнэлэг сургууль хүүхдийн цэцэрлэгийг шилэн кабельд холбох	7,412.0	
10	Чандмань-Өндөр сумын ЗДТГ, эмнэлэг сургууль хүүхдийн цэцэрлэгийг шилэн кабельд холбох	6,771.9	
11	Баянзүрх сумын ЗДТГ, эмнэлэг сургууль хүүхдийн цэцэрлэгийг шилэн кабельд холбох	7,880.0	
12	Улаан-Уул сумын ЗДТГ, эмнэлэг сургууль хүүхдийн цэцэрлэгийг шилэн кабельд холбох	10,279.0	
13	Алаг-Эрдэнэ сумын ЗДТГ, эмнэлэг сургууль хүүхдийн цэцэрлэгийг шилэн кабельд холбох	11,175.1	
14	Жаргалант сумын ЗДТГ, эмнэлэг сургууль хүүхдийн цэцэрлэгийг шилэн кабельд холбох	8,351.0	
15	ШинэИдэр сумын ЗДТГ, эмнэлэг сургууль хүүхдийн цэцэрлэгийг шилэн кабельд холбох	10,577.0	
16	Галт сумын ЗДТГ, эмнэлэг сургууль хүүхдийн цэцэрлэгийг шилэн кабельд холбох	7,234.0	
17	Төмөрбулаг сумын ЗДТГ, эмнэлэг сургууль хүүхдийн цэцэрлэгийг шилэн кабельд холбох	6,499.0	

18	Эрдэнэбулган сумын ЗДТГ,эмнэлэг, сургууль, хүүхдийн, цэцэрлэгийг шилэн кабельд холбох	6,000.0	
19	Тендерийн баримт бичиг борлуулсны орлого. Гэрээт ажилтны хөлс 8150.0, унаа хоолны хөнгөлөлт, НДШ-1815.0, бичиг хэрэг-2980, тээвэр шатахуун-1110.0, шуудан холбоо, интернет-2530.0, ном хэвлэл худалдан авах зардал-5750.0 /ХАА-ны алба/	25500.0	Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2013 оны 43-р тогтоол
2. Аймгийн орон нутгийн төсвөөс хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт -680090,0			
1	Багт цахилгаан шугам татах	102000,0	Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний 295 -р заалт
2	Аймгийн төвийн цэцэрлэгүүдийн сантехникийн засвар	100,000.0	Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний 87 -р заалт
3	Нийтийн тээврийн үйлчилгээнд автобус худалдан авах	60,000.0	Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний 154 -р заалт
4	Галт Мөрөнгийн хоорондох 2 хясааны замыг засаж сайжруулах	20,000.0	
5	Гэрэлтүүлэг засвар үйлчилгээ	20,000.0	Аймгийн төр шашны зөвлөлийн 2014 оны 2 сарын 14- өдрийн хурлын тэмдэглэл
6	Хөлбөмбөгийн талбайг шинээр барих ажлын санхүүжилтийн дутуу	87090,0	Монгол улсын засгийн газрын 2007 оны 349-р тогтоол
7	Жалханз гэгээний 140 жилийн ойд зориулсан хөшөө дурсгал цогцолбор босгох	50,000.0	2013 оны 4 сарын 08-ны өдрийн Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 23-р тогтоол
8	Зүүн мөрөн хорооллын усан хангамжийн гүний худаг гаргах	35,000.0	Шинэ хороолол барьж эхлэх болсонтой холбогдуулан усны эх үүсвэрийг шийдвэрлэх шаардлагатай
9	Тариалан сумын ЗДТГ-ын албан ажлын машиныг шинэчлэх	30.000	Монгол улсын засгийн газрын 2007 оны 349-р тогтоол
10	Мөрөн сумын 6.12-р хороонд 480 м хатуу хучилттай зам шинээр нэмж хийх	166,000.0	Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн хуралдааны 2014 оны 33-р тогтоол
11	Нэгдсэн эмнэлгээс урагшаа дулааны 575м шугамыг өргөсгөх	10000,0	ЗЗНДНТУТХ-ийн 29.1.4-ын " д" Монгол улсын төсвийн тухай хуулийн 58.2.2
3. Тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангахад зориулж аймгийн нөөц санд тусган хэрэгжүүлэх 114120.0			
1	Аймаг орон нутгаа сурталчлан таниулах Монголын үндэсний радио телевизийн нээлттэй өдрийн Хөвсгөл аймагт зохион байгуулж Аймаг орон нутгаа сурталчлах зардалд	34,120.0	Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний 125 -р заалт

2	Цагаан Уул,Цэцэрлэг нутгийн хонийг омгоор баталгаажуулах судалгааны зардал	10,000.0	
3	Алонгоо эхийн сургаалийн баярын бэлтгэл ажлыг хангах	20,000.0	Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдын хуралдааны оны -р тогтоол
4	Оюунлаг Хөвсгөл хөтөлбөрийг санхүүжүүлэх	50000,0	Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдын хуралдааны оны -р тогтоол
4. Аймгийн байгаль хамгаалах сан 45000.0			
1	Ханжаргалант оршуулгын газрыг цэвэрлэхэд	20000.0	Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний 243.257 -р заалт, тусгай сангийн тухай хуулийн 12.2.2, 12.2.48 12.2.8
2	Байгаль хамгаалах хууль тогтоомжийг сурталчилах /Байгаль хамгаалах сангийн 2013 оны дансны үлдэгдлээс/	25000,0	
5. Замын сан 21000.0			
1	"Тэс" дэлгүүрийн уулзвараас нисэх буудал хүртэлх хатуу хучилттай авто замын засвар	21,000.0	Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн хуралдааны 2014 оны 33-р тогтоол
	ДҮН	1,164,929.0	
	Эх үүсвэр	1,164,929.0	

“Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2014 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн” гүйцэтгэлийн аудитаар: Төсвийн тухай хуулийн 29.4-т “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана” гэж заасан ч төсвийн тодотголоор баталсан зарим төсөл, арга хэмжээнүүдэд ТЭЗҮ хийгдээгүй зөрчил илэрсэн.

Мөн тодотголоор: Монгол улсын Засгийн Газрын 2014 оны 04 дүгээр сарын 129-р тогтоол, Сангийн сайд хүн амын хөгжил нийгмийн хамгааллын сайдын 2014 оны 03 сарын 01/02 тоот албан даалгаварт Нийгмийн халамж асрамж үйлчилгээний зардлын төсвийг аймаг, сумын төсөвт хуваарилахаар чиглэл өгсний дагуу сумын Засаг даргын шийдвэрээр зарцуулагдаагүй доорхи зардлыг аймгийн төсөвт хуваарилсан байна.

- 1, Халамжийн тэтгэвэр
- 2, Жирэмсэн нярай, хөхүүл эхийн тэтгэмж
- 3, Хүнс тэжээлийн тусламж,дэмжлэг
- 4, Банкны шимтгэл

5. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлэх нийгмийн халамжийн үйлчилгээ, Ахмад настанд үзүүлэх хөнгөлөлт үйлчилгээний зардлаас Протез,ортопедийн зардал/ Ортопед, протезийн зардлыг сумдад хуваарилснаас шалтгаалан нэг суманд зардал нь хүрэхгүй байхад нөгөө суманд нь үлдэгдэлтэй байгааг байдлыг аймгийн хэмжээнд зохицуулан шийдвэрлэх зорилготой гэсэн зарчмаар ажилласан байна.

- ✚ Хөвсгөл аймгийн Засаг даргын 2014 оны 12 дугаар сарын 24-ний А/461 тоот захирамжаар орон нутаг, тусгай зориулалтын шилжүүлгийн зарим байгууллагын зардал хооронд 465.0 сая төгрөгөөр төсөвт **өөрчлөлт оруулсан байна.**

Орон нутгийн төсвийн талаар:

Зарлага, төсөл санд 2013 оны тухайд нийт төсвийн 97,6% нь урсгал зардалд, 2,4% нь хөрөнгийн зардалд хуваарилагдаж байсан бол 2014 оны төсвийн 93,1% нь урсгал зардалд, 6,9% нь хөрөнгийн зардалд хуваарилагдсан байна. Үүнээс харахад 2014 онд **урсгал зардлыг** 2013 оныхоос бууруулж **хөрөнгийн зардлыг** нэмэгдүүлсэн байна.

Үзүүлэлт	2013 оны нийт төсөв	Хувь	2014 оны нийт төсөв	Хувь
Урсгал зардал	26261.9	97.6	27809.5	93.1
Хөрөнгийн зардал	657.2	2.4	2068.6	6.9
Дүн	26919.1	100	29878.1	100

Аймгийн 2014 оны орон нутгийн төсвийн 80,6 хувийг урсгал зардлын төсөв, 19,4 хувийг хөрөнгийн зардалд зарцуулахаар баталсан, гүйцэтгэлээр төсвийн урсгал зардалд 83,9 хувийг, 16,1 хувийг хөрөнгийн зардалд зарцуулсан байна.

Урсгал зардлын 1,5 хувийг тээвэр шатахууны зардалд төсөвлөж зарцуулсан байна. *Зардлын гүйцэтгэлийг авч үзвэл:* Урсгал зардлыг 0,39 хувиар хэмнэсэн, хөрөнгийн зардлын 79,3 хувийг зарцуулсан ба энэ нь ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих төсөл арга хэмжээний санхүүжилт дутуу санхүүжигдсэнтэй холбоотой байна.

Бүлэг 1. Орон нутгийн төсвийн орлого, зарлагын төлөвлөлтийн үндэслэл

Засаг захиргаа, нутаг дэвсгэр нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хуульд заасан аймгийн ИТХурлын бүрэн эрхэд халдаж ИТХ-ын баталсан төсвийг аймгийн Засаг даргын захирамжаар өөрчилсөн байна. Мөн төсвийн жилийн дундуур тодотголыг 2 удаа хийсэн боловч аймгийн Засаг даргын захирамжаар төсөвт улирал бүр зохицуулалт хийж байгаа зэрэг нь төсвийн төлөвлөлт, хуваарилалт үндэслэл муутай хийгдэж байгааг илэрхийлж байна. Тухайлбал:

Аймгийн засаг даргын 2014 оны 12 дугаар сарын 24-ний А/461 тоот захирамжаар Халамжийн сангийн зардалд 20,9 сая төгрөгийн, улсын төсвөөс санхүүжих санхүүгийн дэмжлэгийг 20,9 сая төгрөгөөр бууруулан өөрчлөлт хийсэн нь Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.2 заалтыг зөрчсөн байна.

Тусгай шилжүүлгийн байгууллагуудын төсөвт хийсэн зохицуулалтаар: ЕБС-ийн төсөвт 614,9 сая төгрөгөөр, СӨБ-ын төсөвт 160.5 сая төгрөг зэрэг байна. Зохицуулалт хийсэн дүнгээс харахад Эрдмийн далай цогцолбор сургуулийн төсвөөс 62.8 сая төгрөгийн, Ирээдүй сургууль 14,3 сая төгрөгөөр, аврагууд сургууль 7,8 сая төгрөгөөр хасах, бусад байгууллагуудад 2.7-63.0 сая төгрөгөөр

нэмэх тодотгол хийсэн, зарим сургуулийн төсөв хүрэлцээгүйгээс 30 гаруй сая төгрөгийн өртэй гарсан зэрэг нь төсвийг үндэслэлгүй төсөвлөж байгааг харуулж байна.

Халамжийн сангийн 2013 оны зардлын 1016.3 сая төгрөгийн зарцуулагдаагүй үлдэгдлийг орон нутгийн төсвийн урсгал зардалд зарцуулсан ба тайлант 2014 онд 1221,1 сая төгрөгөөр санхүүжилтийг дутуу санхүүжүүлэн орон нутгийн ерөнхий орлогын дансанд үлдээсэн байна.

2014 онд орон нутгийн орлогод **2 удаа нийт 527,2 /ХАОАТ-271,7, Үл хөдлөх хөрөнгийн албан татвар-100,0, газрын төлбөрийн орлого-30,0, төсөвт байгууллагын өөрийн орлого-25,5, ОНӨААГ-ын орон нутгийн өмчид ноогдох ногдол ашиг-100,0/ сая төгрөгөөр тодотгол хийсэн байна. Энэ нь Сангийн яамны хянасан орлогоос давсан орлогын болон тодотгол хийсэн дүнгээр нийт **1122,1** сая төгрөгөөр зөрүүтэй байна.**

Орлого давахад нөлөөлсөн дараах орлогуудыг урьдчилан тооцох боломжгүй болон эрхзүйн актуудад өөрчлөлт орсонтой холбогдуулан гүйцэтгэл гарсан нөлөөллийг тооцвол:

Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого: БОНХЯамнаас 2014 онд ахуйн зориулалтаар бор гөрөөс, зэрлэг гахай, загас зэрэг ан амьтныг агнах барих зөвшөөрлийг олгосонтой холбоотой **45,4** сая төгрөгөөр орлого давсан.

Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэсний төлбөрийн орлого: МУ-ын Засгийн газрын 2014 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн 307 тоот тогтоолд “Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” ойгоос бэлтгэсэн хэрэглээний болон түлээ, модны үнэ өссөнтэй холбогдуулан **88.1** сая төгрөгөөр орлого давсан.

Иймд давсан орлогын дүнгээс дээрх орлогуудын нөлөөллийг эс тооцоход **988.6** сая төгрөгөөр давсан байна. Давсан орлогууд нь урьдчилан тооцох боломжтой орлогууд байгаа тул өмнөх жилүүдэд төсвийн төсөлд манай байгууллагаас өгсөн санал үндэслэлтэй байгааг харуулж байна.

Орон нутгийн төсвийн орлого

Орон нутгийн төсвийн орлогын 89,3 хувийг тусламжийн /санхүү дэмжлэг/, 9.6 хувийг татварын, 0.9 хувийг татварын бус, 0.09 хувийг хөрөнгийн орлого бүрдүүлж байгаа бөгөөд төсвийн гүйцэтгэлийг бүрэлдэхүүнээр харуулбал: /сая төгрөгөөр/

Орлогын нэр, төрөл	төлөвлөгөө	гүйцэтгэл	Биелэлт
Татварын орлого	7896,7	8335,8	105,5
Татварын бус орлого	619,0	823,2	132,9
Хөрөнгийн орлого	90,6	79,8	88,2
Тусламж, санхүүжилтийн орлого	80363,3	77286,8	96,2
Нийт орлого ба тусламж санхүүжилтийн орлогын дүн	88969,6	86525,7	97,2

Орон нутгийн татварын орлого 5.5 хувиар буюу 439.1 сая төгрөгөөр, татварын бус орлого 32.9 хувиар буюу 204.2 сая төгрөгөөр давж биелсэн боловч хөрөнгийн орлого 11.8 хувиар буюу 10.8 сая төгрөгөөр, тусламж, санхүүжилтийн орлого 3.8 хувь буюу 3076.5 сая төгрөгөөр тасарсан байна. Энэ нь улсын төсвөөс санхүүжигдэх орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг 3070.4 сая төгрөгөөр, Хүүхэд гэр бүл хөгжлийн хэлтсийн санхүүжилт 6.1 сая төгрөгөөр тус тус дутуу санхүүжигдсэнтэй холбоотой байна.

Орон нутгийн төсвийн орлогын 2014 оны батлагдсан төсвийг өмнөх онтой харьцуулбал:

2014 онд татварын орлого 105,5 хувьтай, татварын бус орлого 132,9 хувьтай байсан нь 2013 оныхоос татварын орлого 10.4 хувиар, татварын бус орлого 0,3 хувиар тус тус нэмэгдсэн байна.

Бүлэг 2. Орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэл

Татварын орлогоор тайлант онд орон нутгийн төсөвт 9117,4 сая төгрөг төвлөрч, төлөвлөгөөг 594,9 сая төгрөгөөр буюу 106.9 хувиар давуулан биелүүлжээ.

Харин Сангийн яамны хянасан төсвөөр тооцвол: Хөвсгөл аймгийн 2014 оны суурь орлогын хязгаар 8127,8 сая төгрөг, гүйцэтгэлээр 9117,4 сая төгрөг байна.



Орлогыг бүтцээр нь харуулбал:

Нийт орлогын : Аймгийн орлого 75 хувийг, сумын орлого 25 хувийг эзэлж байна.

Хөвсгөл аймгийн төсвийн орлогын 2014 оны гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

№	Сумын нэр	Нийт дүн		Биелэлтийн хувь	Зөрүү
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
25	Сумын төсвийн орлогын дүн	1,735,851.10	2,163,664.10	124.6	427,813.00
26	Аймгийн төсвийн орлогын дүн	6,786,697.50	6,953,731.10	102.5	167,033.60

27	Нийт төсвийн орлогын дүн	8,522,548.60	9,117,395.20	107	594,846.60
----	--------------------------	--------------	--------------	-----	------------

Хөвсгөл аймгийн татварын орлогын 2014 оны биелэлт


/мянган төгрөгөөр/

№	Орлогын нэр төрөл	Нийт дүн		Гүйцэтгэлийн хувь	Зөрүү
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Цалин түүнтэй адилтгах орлого	6,055,010.1	6,071,195.2	100.3	16,185.1
2	ХХОАТ-ын буцаан олголт	-803,858.3	-803,805.8	100.0	52.5
3	Үйл ажиллагааны орлого	258,359.2	476,457.3	184.4	218,098.1
4	Хөрөнгө борлуулсны орлого	90,584.0	79,897.3	88.2	-10,686.7
5	Шууд бус орлого	73,040.2	125,775.4	172.2	52,735.2
6	ОТБТБАҮХЭИргэний ОАТатвар	21,085.0	16,088.6	76.3	-4,996.4
7	Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	320,015.6	368,260.3	115.1	48,244.7
8	Бууны албан татвар	11,184.0	12,547.0	112.2	1,363.0
9	АТБӨЯХэрэгслийн албан татвар	395,306.4	416,041.2	105.3	20,734.8
10	Улсын тэмдэгтийн хураамж	296,174.2	296,990.0	100.3	815.8
11	Түгээмэл тархацтай АМАТ	41,458.5	23,765.4	57.3	-17,693.1
12	Хог хаягдлын үйлчилгээний төлбөр	144,762.0	149,450.7	103.2	4,688.7
13	Ашигт малтмалаас бусад байгалийн баялаг ашиглахад олгох эрхийн зөвшөөрлийн хураамж	4,260.0	1,285.3	30.2	-2,974.7
14	Бусад татвар	6,550.0	5,995.0	91.5	-555.0
15	Газрын төлбөр	272,250.0	217,437.9	79.9	-54,812.1
16	Дуудлага худалдаа	52,631.0	79,573.9	151.2	26,942.9
17	Ойн нөөц ашигласны төлбөр	653,502.6	741,606.4	113.5	88,103.8
18	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	25,948.8	71,391.2	275.1	45,442.4

19	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	47,798.1	54,029.3	113.0	6,231.2
20	Байгалийн ургамлын НАТөлбөр	21,257.2	11,782.1	55.4	-9,475.1
Татварын орлогын дүн		7,987,318.6	8,415,763.6	105.4	428,445.0
26	Хувьцааны ногдол ашиг	103,000.0	102,451.3	99.5	-548.7
28	Хүү, торгуулийн орлого	388,536.0	446,160.9	114.8	57,624.9
29	Түрээсийн орлого	0.0	671.0		671.0
30	Бусад орлого	1,694.0	106,012.6	6,258.1	104,318.6
31	Төрийн болон ОНӨ бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого	42,000.0	46,335.9	110.3	4,335.9
36	Төсөвт байгууллагын өөрийн орлого	83,783.0	121,548.3	145.1	37,765.3
Татварын бус орлогын дүн		619,013.0	823,180.0	133.0	204,167.0
Нийт орлогын дүн		8,606,331.6	9,238,943.6	107.4	632,612.0

Аймгийн төсөвт орох татварын болон татварын бус орлогын төлөвлөгөө 107,3 хувийн биелэлттэй 632,6 сая төгрөгөөр давж биелсэн боловч улсын төсвөөс олгох тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын санхүүжилт төлөвлөснөөс -6,1 сая төгрөгөөр, орон нутгийн хөгжлийн сангийн шилжүүлэг 3070,4 сая төгрөгөөр дутуу олгогдсоноос аймгийн нийт орлогын төлөвлөгөө тасалдсан байна.

Орлогын нэр төрлөөр авч үзвэл орлого тодорхойлох боломжгүй иргэний орлогын татвар, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр, ашигт малтмалаас бусад байгалийн баялаг ашигласны төлбөр, газрын төлбөр, байгалийн ургамал ашигласны төлбөр зэрэг орлогын төлөвлөгөө тасалдсан байна.



Сүүлийн 6 жилийн үзүүлэлтээр давсан орлого байнга өсөн нэмэгдэх хандлагатай байсан боловч 2014 онд орон нутгийн орлогын давалт буурсан байна.

Аймгийн Аудитын газраас орон нутгийн орлогын төлөвлөгөөг үндэслэлтэй, суурь судалгаанд тулгуурлан,

үнэн бодит байдалд нийцүүлэн төлөвлөж байх, орлогын төлөвлөгөө гүйцэтгэлийн зөрүүг ойртуулах зөвлөмж хүргүүлэн ажилласан боловч төсвийн жилийн дундуур

тодотгол хийсэн дүнгээр тооцвол 2014 онд орон нутгийн орлогын төлөвлөлтийн түвшинг тогтоох боломжтой байна. Төсвийн жилийн дундуур төсвийн орлогод тодотгол хийж байгаа нь төсвийн төслийн судалгаа үндэслэлтэйгээр боловсруулан Сангийн яаманд хянуулж, аймгийн ИТХуралд өргөн мэдүүлж батлуулж чадахгүй байгааг харуулж байна.

Орон нутгийн орлогын төлөвлөгөө давж биелэхэд ихээхэн нөлөөлсөн орлогуудыг авч үзвэл:

-Үйл ажиллагааны орлого 218,1 сая төгрөгөөр давсан нь арьс ширний урамшуулал 2014 онд шинээр олгогдсон ба төлөвлөлт хийх үед арьс ширний урамшууллыг олгох, эсэх нь тодорхойгүй байсан тул төлөвлөгөөнд тусгагдаагүй байсан бөгөөд урамшууллаас татвар суутган тооцож орон нутгийн орлогод төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

-Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого 45,4 сая төгрөгөөр давж биелсэн ба энэ нь БОНХЯамнаас 2014 онд ахуйн зориулалтаар бор гөрөөс, зэрлэг гахай, загас зэрэг ан амьтныг агнах барих зөвшөөрөл БОАЖЯамнаас олгохгүй гэж байсан боловч 7-р сард зөвшөөрөл олгосон, мөн Ханх суманд загас агнуурын тэмцээн зохион байгуулж 6600,0 мянган төгрөг орсон. Тусгай зориулалтаар барих тул загасны тоо 100 ширхэгээр тооцож байсан бол компаниудын хүсэлтээр 100 ширхэгээр нэмж олгосон зэрэг шалтгааны улмаас агнуураас орох орлого давж биелсэн байна.

-Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэсний төлбөрийн орлого: Аймгийн хэмжээнд Ойгоос хэрэглээний мод түлээ бэлтгэж ашигласны төлбөрөөс 653,5 сая төгрөг орохоос 741,6 сая төгрөгийн гүйцэтгэлтэй 88,1 сая төгрөгөөр давж биелсэн байна.

МУ-ын Засгийн газрын 2014 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн 307 дугаар "Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай" тогтоолоор ойгоос бэлтгэсэн хэрэглээний болон түлээ, модны үнэ өссөн.

Уг тогтоолыг аймгийн хэмжээнд 11 дүгээр сарын 06-наас хойш мөрдөж ажилласнаар ойгоос орох хэрэглээний мод түлээ бэлтгэж ашигласны төлбөр 88,1 төгрөгөөр давахад нөлөөлсөн гэж үзэж байна.

Татварын бусад орлого: Аймгийн татварын бусад орлогод 79.7 сая төгрөгийн төлөвлөгдөөгүй гүйцэтгэл орж ирсэн нь Аймгийн Аудитын газрын аудитын үйлчилгээ үзүүлсний төлбөрийн орлого, актын орлогууд бүртгэгддэг ба энэ төлбөрийн орлого нь ҮАГазарт шилжих тул орон нутгийн орлогын төлөвлөгөөнд тусгагдахгүй гүйцэтгэлд нь тусгагдсан нь орлогын давалтанд тодорхой хэмжээгээр нөлөөлж байна.

Орлого тасарсан шалтгааныг судлан үзвэл:

-Хөрөнгө борлуулсны орлого 10,6 сая төгрөгөөр тасарсан байна.

-Орлого тодорхойлох боломжгүй иргэний орлогын албан татвар: Орлого тодорхойлох боломжгүй иргэд орлогоо тодорхойлон татвараа төлснөөр татвар нь

үйл ажиллагааны татвар руу шилжсэн мөн зарим бүртгүүлсэн патент төлөгч нар үйл ажиллагаагаа явуулах боломжгүй болсон.

-Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлого: Тасалдлын гол шалтгаан нь Сацын булангийн гүүр барьж байгаа "Эрдэнэт суварга" компани 2014 онд 14592.0 мянган төгрөгийн ТТАМАТ-ийг төлөөгүй.


-Газрын төлбөрийн орлого: Газар эзэмшигчид газраа үл хөдлөх болгон бүртгүүлж газар эзэмшигчдийн тоо буурч байна. Мөн Бүрэнтогтох сумын газрын төлбөрийн орлого 22.6 сая төгрөгөөр тасарсан нь тасалдалд ихээхэн нөлөөлж байна. 2014 онд Мон ажнай, ШШГА, Хөвсгөл зам ХХК зэрэгт газрын төлбөрийн орлогоо төлөөгүй. Фосфоритын ордын ашиглалтын лиценз эзэмшдэг ААН-д шүүх дээр бүх материал байгаа лиценз эзэмших эрх цуцалсан тиймээс төлөх боломжгүй болоход хүргэсэн.

Ургамлын нөөц ашигласны төлбөрийн орлого: 2014 онд жимс, самрын ургац бага байсан ба хээрийн цагаан мөөг, цайны ургамал бэлтгэж буй аж ахуйн нэгжүүдийн тоо буурсан.

БҮЛЭГ 3 . Орон нутгийн төсвийн зарлагын гүйцэтгэл

Монгол Улсын 2014 оны төсвийн зарлагын бодлого нь төсвийн үргүй зардлыг багасгах болон төсвийн хөрөнгө оруулалтыг ач холбогдлоор нь эрэмбэлж, тэргүүлэх чиглэлүүдэд төвлөрүүлэх, үр өгөөжтэй хөгжлийн томоохон төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэгдсэнтэй холбогдуулан Хөвсгөл аймгийн 2014 оны орон нутгийн төсвийн зарлага 92831,08 сая төгрөг батлагдсанаас 88188,6 сая төгрөг зарцуулж 94,9 хувийн гүйцэтгэлтэй, өмнөх онтой харьцуулахад 11,5 хувийн өсөлттэй гарсан нь ОНХСангийн санхүүжилт дутуу санхүүжигдсэн, тодотголоор зардлыг бууруулснаас шалтгаалжээ.

Орон нутгийн төсвийн зарлагыг өмнөх онтой зэрэгцүүлэн графикаар үзүүлбэл:



Дээрх графикаас харахад: Хөвсгөл аймгийн орон нутгийн төсвийн гүйцэтгэлээр өмнөх онд нийт зарлагын 28.5 хувийг орон нутгийн, 14.5 хувийг Халамжийн сангийн, 56.9 хувийг тусгай зориулалтын шилжүүлгийн төсөв тус тус эзэлж байсан бол 2014 онд орон нутгийн төсвийн эзлэх хувийн жин 15.7 хувиар, өсч, харин тусгай зориулалтын шилжүүлгийн төсвийн хувийн жин 0.8 хувиар, Халамжийн сангийн төсвийн эзлэх хувийн жин 0.8 хувиар тус тус буурсан байна.

Урсгал зарлага

Аймгийн 2014 оны орон нутгийн төсвийн зарлагын гүйцэтгэлийн 86,1 хувийг урсгал зардал, 13,9 хувийг хөрөнгийн зардал тус тус эзэлж байна.

Хөвсгөл аймгийн 2014 оны орон нутгийн төсвийн зардлыг нэр төрлөөр харуулбал:

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх он	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Гүйцэтгэл Хувир	Эзлэх хувь
НИЙТ ЗАРЛАГА	79025.9	92831,0	88188,6	94.9	100
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	70826,3	77361,8	75958,3	98,1	86,1
Бараа, үйлчилгээний зардал	55665,6	59303,4	59064,7	99,6	
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	35126,7	38401,3	38350,4	99,8	
БАРАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УРСГАЛ ЗАРДАЛ	16688,1	16654,4	16468,2	98,7	
Тогтмол зардал	5417,8	5495,5	5436,3	98,9	
Бараа, үйлчилгээний бусад зардал	11270,2	11157,9	11031,9	98,8	
Тээвэр шатахуун	964,0	998,6	1005,2	100,6	
Шуудан холбоо	140,0	166,3	157,2	94,5	
Дотоод албан томилолт	431,4	332,6	319,6	96,1	
Гадаад томилолт/арга хэмжээ/	3,8	13,8	10,4/13,4	75,3/97,1	
Татаас ба урсгал шилжүүлэг	15160,6	18058,3	16893,6	93,5	
Нийгмийн халамжийн зардал	11512,3	13256,4	12071,0	91,0	
Хөрөнгийн зардал	8199,6	15469,2	12230,3	79,0	13,9

Хөвсгөл аймгийн төсвийн нийт урсгал зарлагад 75958,3 сая төгрөг зарцуулж 98.1 хувийн гүйцэтгэлтэйгээс 56,1 хувийг цалин, нийгмийн даатгалын шимтгэл, 14,5 хувийг бараа, үйлчилгээний бусад зардал, 7,1 хувийг тогтмол зардалд, 22,2 хувийг татаас ба урсгал шилжүүлэгт тус тус зарцуулсан нь өмнөх онуудтай харьцуулбал:

сая төгрөгөөр

Зардлын бүлэг	2013 он	2014 он		Гүйцэтгэл зөрүү
	гүйцэтгэл	төлөвлөгөө	гүйцэтгэл	
Урсгал зарлага	70826,2	77361,8	75958,3	5132,1
Цалин, нийгмийн даатгалын шимтгэл	38977,5	42649,0	42596,5	3619,0
Тогтмол зардал	5417,8	5495,4	5436,3	18,5
Бараа, үйлчилгээний бусад зардал	11270,2	11158,9	11031,9	238,3
Татаас ба урсгал шилжүүлэг	15160,6	18058,3	16893,6	1733,0

Цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал өмнөх оны гүйцэтгэлээс **7,2** хувиар өссөн нь 2014 онд төрийн албан хаагчдын цалинг үе шаттайгаар өсгөсөнтэй холбоотой байна.

2014 оны байдлаар орон нутгийн төсвийн байгууллагын албан хаагчдын тоо 5235-д хүрч төлөвлөгөөнөөс 11 хүнээр, үүнээс удирдах ажилтны тоо 4-өөр, хэмнэсэн, гүйцэтгэх ажилтны тоо 41-ээр, үйлчлэх ажилтны тоо 65-аар тус тус хэтэрсэн байна.

Нийт төсвийн 80,6 хувийг урсгал зардлын төсөв, 19,4 хувийг хөрөнгийн зардалд зарцуулахаар баталсан, гүйцэтгэлээр төсвийн урсгал зардалд 83,9 хувийг, хөрөнгийн зардалд 16,1 хувийг зарцуулсан байна.

Урсгал зардлын 1,5 хувийг буюу 998,6 сая төгрөгийг тээвэр шатахууны зардалд төсөвлөсөн нь өмнөх оноос 34,6 сая төгрөгөөр нэмэгдсэн ба 1005,2 сая төгрөгийн гүйцэтгэл гарсан байна.

Аудитын хугацаанд авсан судалгаагаар:

Нийт 95 суудлын болон бусад зориулалтын автомашин бүртгэгдсэн бөгөөд үүний 13,6 хувь буюу 13 автомашин нь өндөр үнэтэй, шатахууны зарцуулалт ихтэй Lexus 470, Land cruiser 200, 100, 105 маркийн автомашиныг ашиглаж байна.

Шатахуун их зарцуулдаг, өндөр үнэтэй автомашинаас аль болох татгалзан төсвийн үр ашгийг дээшлүүлэн, хэмнэлтийн горимд шилжиж ажиллах талаар албан шаардлага хүргүүлэв.

Шуудан холбооны зардал 94,5 хувийн гүйцэтгэлтэйгээр баталсан төсвийн 5.5 хувиар хэмнэсэн хэдий ч судалгаагаар 25,3 сая төгрөгийн гар утасны төлбөрийг төсвийн урсгал зардлаар санхүүжүүлсэн байна.

Гадаад албан томилолтын зардал АТЕЗ-ийн тайлан дахь дүнгээр 75.3 хувийн гүйцэтгэлтэй буюу 3.4 сая төгрөгөөр төсвийг хэмнэсэн мэт тайлагнасан боловч төсвийн гүйцэтгэлийн мэдээгээр 97.1 хувийн гүйцэтгэлтэй буюу 0.4 сая төгрөгөөр хэмнэсэн байна. Эдгээрээс харахад батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргаж

байгаа боловч тэвчиж болох зардлуудыг төдийлөн хэмнэх арга хэмжээ авахгүй байгаа нь харагдаж байна.

Зардлын гүйцэтгэлийг авч үзвэл: Урсгал зардлыг 0,39 хувиар хэмнэсэн, хөрөнгийн зардлын 79 хувийг зарцуулсан байна. Хөрөнгийн зардлын гүйцэтгэл дутуу байгаа нь ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих төсөл арга хэмжээний санхүүжилт 3070,4 сая төгрөгөөр дутуу санхүүжигдсэнтэй холбоотой байна.

Санхүүгийн дэмжлэг, зарлагын гүйцэтгэлийн талаар

УИХ-ын 2014 оны 12 дугаар сарын нэгдсэн хуралдаанаар баталсан төсвийн тодотголын дагуу төсөвт өөрчлөлт орсон дүнгээр тооцов.

- + Орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэгээр 18912,2 сая төгрөг төлөвлөснөөс УИХ-ын төсөвт тодотгол хийгдсэний дагуу 18891,3 сая төгрөг болж өөрчлөгдснөөс 18891,3 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна.
- + Орон нутгийн хөгжлийн санд олгох санхүүжилтэд 12840,6 сая төгрөг төсөвлөснөөс УИХ-аас баталсан төсвийн тодотголоор 11997,6 сая төгрөг болгон бууруулсан, гүйцэтгэлээр 8927,2 сая төгрөг буюу 69,5 хувьтай гарсан байна.
- + Тусгай зориулалтын шилжүүлгийн талаар
Тусгай зориулалтын шилжүүлгээс 49474,3 сая төгрөг төсөвлөснөөс гүйцэтгэлээр 49468,2 сая төгрөг буюу 99,9 хувийн гүйцэтгэлтэй байна.

Тусгай шилжүүлгийн зарлагын гүйцэтгэлийн 81.6 хувийг Боловсролын байгууллагад, 5.2 хувийг Соёлын байгууллагуудад, 11.9 хувийг Эрүүл мэндийн төвүүд, өрхийн эмнэлгүүдэд, үлдсэн 1.3 хувийг бусад ТШЗ-дын зарлага эзэлж байна.

Нийгмийн халамжийн зардал

Төсвийн тухай хуулийн 58.2.4 заалтын дагуу орон нутаг өөрийн төсвөөр нийгмийн халамж үйлчилгээ үзүүлэх болсон тул 2013 онд аймгийн Халамжийн санд 12573,5 сая төгрөг төлөвлөгдсөн ба гүйцэтгэлээр 11518,9 сая төгрөгийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж болон бусад үйлчилгээг үзүүлсэн байна. Харин 2014 оны хувьд дараах байдалтай байна. Үүнд:

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/ 2014 он		
	АТЕЗ-ийн тайлангаар		Аудит хийсэн
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Гүйцэтгэл
НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	13268389,6	12071051,7	12075598,0
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	13268389,6	12071051,7	12075598,0
Нийгмийн халамжийн зардал	13256389,6	12071051,7	12075598,0

Халамжийн тэтгэвэр	5009556,7	4638088,9	4663620,5
Жирэмсэн, амаржсан эхийн тэтгэмж	1765504,1	1676027,3	1673155,2
Халамжийн бусад хөнгөлөлт-үйлчилгээ	498200,0	505789,4	463880,0
Нөхцөлт мөнгөн тусламж	3196218,4	3030373,4	3030493,4
Олон нийтийн оролцоонд тйшиглэсэн халамжийн йлчилгээ	439800,0	259478,6	256028,5
Халамжийн үйл ажиллагааны зардал	5197,5	5197,5	5197,5
Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд йзйллэх нийгмийн халамжийн йлчилгээ	537303,2	364156,1	377408,9
Ахмад настуудад йзйллэх хөнгөлөлт	728325,6	615958,1	624863,9
Хоол тэжээлийн тусламж, дэмжлэг	1081481,6	981180,0	981180,0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	13268389,6	12087998,9	
Төсвөөс санхүүжих	13268389,6	12049821,6	12049569,6
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл		38177,3	38085,7
Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл			11818,4

Дээрх хүснэгтээс харахад: АТЕЗ-ийн нэгтгэсэн тайланд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр нь 2,6 сая төгрөгөөр зөрүүтэй байна. Мөн халамжийн сангийн зардлыг бодит байдалд нийцүүлэхгүй, төлөвлөснөөс 2014 онд 1221,1 сая төгрөгийг аймгийн төрийн сангаас санхүүжүүлээгүй байна.

Нэмэлт төсвийн гүйцэтгэл

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлд нэмэлт төсвийг төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн бүрэлдэхүүн хэсэг байхаар заасны дагуу төсвийн байгууллагуудын нэмэлт төсвийн гүйцэтгэлийг аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд нэгтгэсэн байна.

2014 онд нэмэлт төсвөөр нийт 1888.9 сая төгрөгийн эх үүсвэр төвлөрсөн байна. Үүнд.

- Дээд шатны төсөв захирагчаас доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 0,9 сая төгрөг,
- Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламжаар 3.4 сая төгрөг,
- Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 0.2 сая төгрөг,
- ЗГ-ын болон Засаг даргын нөөц хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгө болон бусад 684,5 сая төгрөг,
- Төсвийн урамшууллаас 15.4 сая төгрөг тус тус төвлөрсөн байна.

Тайлант онд нэмэлт төсвийн гүйцэтгэлээр 1869,7 сая төгрөгийг зарцуулсан ба үүнээс нийт зарлагын 90 хувь буюу 1683,9 сая төгрөгийг урсгал зардал, 10 хувь буюу 185.7 сая төгрөгийг хөрөнгийн зардал эзэлж байна.

Нэмэлт төсвийн урсгал зардлын 5.6 хувь буюу 97.5 сая төгрөгийг татаас, шилжүүлэг хэлбэрээр, 2.2 хувь буюу 37,0 сая төгрөгийг сургалт семинарийн цайны зардалд тус тус зарцуулсан байна.

Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн болон улс, орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн захирагчийн шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байхад нийцүүлэн батлагдсан маягтын дагуу Khovsgol.gov.mn сайтад байршуулж байгаа боловч сумдын ТЕЗ-ийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг шилэн дансанд /байгууллагын цахим хуудсанд/ байршуулаагүйгээрэг нийтлэг зөрчил байна.

Тухайлбал:

- ОНХС-ийн батлагдсан төсөв, АИТХ-ын тогтоолыг байршуулснаас бусад хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалт, тэдгээрийн батлагдсан төсвийг хуулийн дагуу байршуулаагүй байна.
- Аймгийн ТЕЗ-ийн хувьд шилэн дансанд /байгууллагын цахим хуудсанд/ тавих мэдээллүүдийг “khovsgol.gov.mn” сайтад байршуулсан байна. Нийт 11 мэдээлэл тавигдахаас 10 мэдээлэл тавигдаж 1 мэдээлэл буюу шийдвэрийн жагсаалт тавигдаагүй байна.



ДҮГНЭЛТ:

Хөвсгөл аймгийн 2014 оны орон нутгийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Аймгийн 2014 оны орон нутгийн төсвийн орлого 86525.7 сая төгрөгийн гүйцэтгэлтэй гарсан нь анх батлагдсан төлөвлөгөөнөөс 2217,1 сая төгрөгөөр, тодотгосон төлөвлөгөөнөөс 2443,9 сая төгрөгөөр буурсан боловч ихэнх төсвийн захирагч нар тэвчиж болох зардлуудыг хэмнэх талаар төдийлөн арга хэмжээ аваагүй, өндөр үнэтэй, шатахууны зарцуулалт ихтэй Lexus 470, Land cruiser 200, 100, 105 маркийн автомашиныг ашиглаж байна.
2. Сангийн яамны хянасанаар тооцвол орон нутгийн орлогыг 7927,6 мянган төгрөгөөр баталсан, гүйцэтгэлээр 9117,4 мянган төгрөг болж 988.6 сая төгрөгийн зөрүүтэй байгаа нь орлогыг бодитой төлөвлөөгүйг илэрхийлж байна.
3. Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.2 заалтыг зөрчиж Хөвсгөл аймгийн засаг даргын захирамжаар аймгийн халамжийн сангийн зардлыг 20,9 сая төгрөгөөр өөрчлөлт оруулан баталсан байна.
4. Орон нутгийн төсөвт 86525,7 сая төгрөгийн орлого бүрдүүлж 88188.6 сая төгрөгийн зарлага санхүүжилт хийснээр нэгдсэн төсвийн зардалд сумдын төсвийн эзлэх хувь хэмжээ 80.6 хувь болсон байна.
5. Аймгийн 2013 оны орон нутгийн төсвийн гүйцэтгэлд хийсэн гүйцэтгэлийн аудитын зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.



ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг зөвлөж байна. Үүнд:

Аймгийн ИТХ-ын дарга Т.Болдбаатарт:

1. Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2 заалтыг хэрэгжүүлэн төсвийн тогтвортой байдлыг хангасан байх зарчмыг баримтлан аймгийн орон нутгийн төсөв баталж, төсвийн үр ашгийг дээшлүүлэн, төсвийн төлөвлөлт, хяналт, тайлагналын горимыг хэрэгжүүлэх.

***Аймгийн Засаг дарга, ТЕЗахирагч А.Эрдэнэбаатар,
СТСХ-ийн дарга Г. Сүвд нарт:***

1. Дээд шатны төсөвт тодотгол хийгдсэнийг үндэслэн аймгийн орон нутгийн төсөвт тодотголыг хийж Аймгийн ИТХ-аар батлуулж байх.
2. Аймгийн аудитын газраас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн орон нутгийн орлого, зарлагыг бодитой төлөвлөж байх
3. Аймгийн орон нутгийн төсвийн гүйцэтгэлд дүн шинжилгээ хийж, төсвийн шууд захирагч нарыг мэргэжил арга зүйгээр ханган төсвийн төлөвлөлт, үр ашигтай зарцуулах, төсвийн хөрөнгийн ашиглалтыг сайжруулах арга хэмжээ авч ажиллах
4. Орон нутгийн төсвийн урсгал зардал, ялангуяа тэвчиж болох зардлуудыг бууруулах талаар бодитой, үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлэх



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬАА
**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

67123 Хөвсгөл аймаг, Морин сум
Утас: 70-38 37-93 факс: (976) 70-38 37-93

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ
БӨГӨӨД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА
А.ЭРДЭНЭБААТАРТ

ХНС.ОС.АБ № ХАТ-1 АГ/2015/04-ХӨААГ 04/26

Албан тушаалын болон албан
ажлын автомашины хэрэглээг
зохицуулах тухай

Хөвсгөл аймгийн Аудитын газрын 2015 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу Хөвсгөл аймгийн 2014 оны орон нутгийн төсвийн гүйцэтгэлд аудит хийхэд: Аудитаар авсан судалгаагаар 95 суудлын болон бусад зориулалтын автомашин бүртгэгдсэнээс 13 автомашин нь өндөр үнэтэй, шатахууны зарцуулалт ихтэй Lexus 470, Land cruiser 200, 100, 105 маркийн автомашиныг ашиглаж байна. Засгийн газрын "Төсвийг хэмнэлтийн горимд шилжүүлэх зарим арга хэмжээний тухай" 2014 оны 147 дугаар тогтоолын 4 дахь тусуудлын автомашины талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2007 оны 349 дүгээр тогтоолоор тогтоосон албан тушаалын болон албан ажлын автомашины хэрэглээний зардлыг 20 хүртэл хувиар хэмнэх/ заалтын хэрэгжилт хангалтгүй байна.

Иймд: Монгол улсын Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэхь хэсгийн 12-т заасан (... аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналын холбогдох байгууллагад тавих...) заалтыг үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Албан тушаалын болон албан ажлын автомашины хэрэглээний зардлыг хэмнэх Засгийн газрын гаргасан тогтоолыг хэрэгжүүлэн шатахууны зарцуулалт ихтэй, өндөр үнэтэй автомашины хэрэглээг багасгах зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллан үр дүнг 2015 оны 10 дугаар сарын 01-ний дотор аймгийн Аудитын газарт ирүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч, аймгийн засаг дарга А.Эрдэнэбаатарт шаардаж байна.

ШААРДЛАГА БИЧСЭН:

АХЛАХ АУДИТОР

Л.ЭНХ-АМГАЛАН

АУДИТОР

Л.МАГСАРЖАЛАМ

ХХА0122

Холбогдох байгууллагын санал:



АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Аймгийн 2014 оны орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай танилцаж танилцаж тайлбарыг хүргэв.

Хавсралт 5-н хуудас

ДАРГА  Г.СУВД

04 0225

ХӨВСГӨЛ АЙМГИЙН 2014 ОНЫ ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН
ТАЙЛАНД ӨГӨХ ТАЙЛБАР

2015-05-11

№	Аудитын тайланд тусгагдсан	Тайлбар
1	Орон нутгийн орлогыг бодитой төлөвлөхгүйгээс орон нутгийн орлого 6,9 хувиар буюу 594,9 /9117,4-8522,5/ мянган төгрөгөөр давж биелсэн ба зарим орлогын төлөвлөгөө биелээгүй болон огт биелээгүй байна.	Нийт 26 нэр төрлийн татварын болон татварын бус орлого төлөвлөгдсөнөөс: 1.ХАОАТ-ын Хөрөнгө борлуулсны орлого 88,2%, 2.ОТБИОАТ-76,3%, 3.Түгээмэл ТАМАТ-57,3% 4. Ашигт малтмалаас БББАОЭЗХ-30,2% 5. Газрын төлбөр-79,9 % 6. Байгалийн ургамал 55,4 % 7.Татварын бусад татвар-91,5 % буюу 7 төрлийн орлогууд 30,2-91,5 хувиар тасарсан. Гүйцэтгэлийн гараагүй, огт биелээгүй орлого орлогын нэр төрөл байхгүй. Орлого тасархад орон нутгийн байгууллага, татварын байгууллагын үйл ажиллагаанаас хамааралгүй орлого тасрах шалтгаан байна. Тухайлбал: Тасалдлын гол шалтгаан нь: - ХАОАТ-ын Хөрөнгө борлуулсны орлого -Иргэд үл хөдлөх хөрөнгө борлуулснаас 2 хувийг суутгадаг. 2014 онд улс, орон нутагт үүссэн хямрал нь үл хөдлөх хөрөнгийн борлуулалтыг бууруулсан. - ОТБИОАТ -Орлого тодорхойлох боломжгүй иргэд орлогоо тодорхойлон татвараа төлснөөр татвар нь үйл ажиллагааны татвар луу шилжсэн мөн зарим бүртгүүлсэн патент төлөгч нар үйл ажиллагаагаа явуулах боломжгүй болсон. Аймгийн Аудитын газраас 2014 онд ОТБИОАТ-ыг 10,1 сая төгрөгөөр нэмэгдүүлэх санал ирүүлж байсан. - Түгээмэл ТАМАТ : Сацын булангийн гүүр барьж байгаа "Эрдэнэт суварга" компани 2014 онд 14592.0 мянган төгрөгний ТТАМАТ-ийг төлөөгүй. Тухайн компанийг төлбөрийг төлүүлэх талаар Татварын хэлтэс, СТСХ хамтарч дансыг хаах хүртэл удаа дараа арга хэмжээ авч байсан хэдий ч тухайн компаний 2014 онд улсын төсвөөс авах санхүүжилт орж ирээгүй тул энэхүү түгээмэлийн төлбөрийг авах боломжгүй байдалд хүргэсэн.
2	Төсвийн жилийн дундуур төсвийн орлогод тодотгол хийж байгаа нь төсвийн тогтвортой байдлыг хангаж чадахгүй байгааг харуулахаас гадна төлөвлөлтийг үндэслэлтэй хийж байх шаардлагтайг харуулж байна.	Аймгийн Аудитын газрын зөвлөмж, тооцоо судалгаанд үндэслэн орон нутгийн орлогыг 405,7 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталсан нь төсвийн тогтвортой байдлыг ханган ажиллаж байгаа гэж үзэж байна. Төсвийн тухай хуулийн 6.2.Энэ хуулийн 5.1.1-д заасан төсвийн тогтвортой байдлыг хангасан байх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ гэж заасан байдаг. Үүнд: 6.2.1.Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагыг хангах; 6.2.2.жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон

988.6

		санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх; 6.2.3.урьдчилан тооцоолох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, эсхүл зарлага нэмэгдсэнээр төсвийн алдагдал нэмэгдэхээр бол төсвийн зарлагыг бууруулах, эсхүл орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх замаар тухайн жилийн төсөвт тодотгол хийж, төсвийг тэнцвэржүүлэх; 6.2.4.Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, нутгийн өөрөө удирдах байгууллага, Засгийн газар, Засаг даргын аливаа шийдвэр нь төсөвт үзүүлэх нөлөөллийн талаарх дүгнэлтэд үндэслэсэн байх; 6.2.5.төсвийн жилийн дундуур орлого бууруулах, зарлага нэмэгдүүлэх үр дагавартай бодлогын аливаа шийдвэр гаргасан бол түүнийг дараагийн төсвийн жилээс хэрэгжүүлдэг байх. Энэхүү зарчмууд алдагдаагүй тул төсвийн тогтвортой байдал алдагдсан гэж үзэх үндэслэлгүй юм.
3	2014 оны байдлаар орон нутгийн төсвийн байгууллагын албан хаагчдын тоо 5235-д хүрч төлөвлөгөөнөөс 11 хүнээр, үүнээс удирдах ажилтны тоо 4-өөр хэмнэсэн, гүйцэтгэх ажилтны тоог 41-ээр, үйлчлэх ажилтны тоог 65-аар тус тус хэтэрсэн байна.	Орон нутаг болон ТЗШ-ийн байгууллагуудын нийт албан хаагч нь төлөвлөгөөгөөр 5246 ажиллахаас 5235 ажиллаж 11 албан хаагчийн орон тоог хэмнэж ажилласан. Нийт дүнгээрээ орон тоо хэтрээгүй. Зөвхөн гүйцэтгэх, үйлчлэх, гэрээтийн орон тоонууд дотор хөдөлсөн. Гүйцэтгэх ажилтан 41-ээр, үйлчлэх ажилтны тоог 65-аар тус тус хэтэрсэн боловч гэрээт ажилтан энэ хэмжээгээр 106 ажилтнаар дутуу ажилласан. Орон нутгийн байгууллагууд төлөвлөгөөний дагуу ажилласан ба харин энэ хэтэрсэн, дутсан гэх орон тоо нь ТЗШ-ийн байгууллагууд сургууль, цэцэрлэгийн орон тоо юм.
4	33НДНТУТХуулиар орон нутгийн ИТХ-д олгогдсон бүрэн эрхэд халдаж ИТХ-ын баталсан төсвийг ЗД-ын захирамжаар зохицуулалт хийх, төсвийн жилийн дундуур тодотголыг олон дахин хийх зэрэг зөрчил гаргасаар байна.	-Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалын 3.1.4, 5.3 дахь заалтанд заагдсан бүрэн дагуу улиралд нэг удаа зохицуулалт хийх эрхтэй байдаг. Энэ журмынхаа дагуу Аймгийн засаг дарга 2014 онд 4 удаагийн зохицуулалтыг хийсэн. -Төсвийн тодотголыг 2014 онд 1 удаа хийсэн. Аймгийн ИТХ-ын 2014-06-26-ны өдрийн хуралдааны 05 дугаар тогтоолоор 1 удаа төсвийн тодотгол хийгдсэн.
4	-Хөвсгөл аймгийн орон нутгийн төсөвт Засаг даргын захирамжаар өөрчлөлт оруулсан байна. -.....Аймгийн ЗД-ын 2014-12-24-ний А/461	-Аймгийн ТЭЗ-ахирагч өөрийн хамаарах төсөвт Төсвийн тухай хуулийн 14.2.3, 14.2.5, 42.2.1, 42.2.2, 42.3.4, 42.5, Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалын 3.1.4, 5.3 дахь заалтанд заагдсан бүрэн эрхийнхээ хүрээнд зохицуулалтыг хийж төсвийн байгууллагуудын хэвийн үйл ажиллагааг ханган ажилласан. - Энд бичигдсэн тоонуудын оронгийн нарийвчлалыг

	тоот захирамжаар ОН-ын төсвийн байгууллагуудад 34870,0 сая төгрөг, үүнээс Халамжийн сангийн зардалд 20911,4 сая төгрөгийн, ТЗШ-ийн төсөвт 443784,2 сая төгрөгийн зохицуулалт хийсэн нь Төсвийн тухай хуулийн 64.1.2 заалтыг зөрчиж байна. ТЗШ-ийн байгууллагуудын төсөвт хийсэн зохицуулалтаар ЕБС-ийн төсөвт 614,9 сая төгрөг, СӨБ-ын төсөвт 160,5 сая төгрөг зэрэг болно. Зохицуулалт хийсэн дүнгээс харахад төсвийг үндэслэлгүй төсөвлөж байгааг харуулж байна.	мянган төгрөг гэж засах. Тухайлбал: 20911,4 сая төгрөг биш 20911,4 мянган төгрөг гэх мэт. Мөн орон нутгийн байгууллагууд хийсэн зардлын зохицуулалтын дүн 34870,0 мянган төгрөг биш. Орон нутгийн зардал хооронд хийсэн зохицуулалтын дүн 27890,7 мянган төгрөг. -ТЗШ-ийн төсөвт 443784,2 мянган төгрөгийн зохицуулалт хийсэн нь Төсвийн тухай хуулийн 42.2.2-т заагдсанаар Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хувьд Аймгийн Засаг дарга нь түүнд хамаарах төсвийн шууд захирагчдын төсөв хооронд зохицуулалт хийсэн. Төсвийн тухай хуулийн дээрх заалтууд, Сангийн сайдын 73 дугаар тушаалын хүрээнд зохицуулалт хийж зохицуулалт хийх заалт, журмыг зөрчөөгүй. Харин тайланд тусгагдсан Төсвийн тухай хуулийн 64.1.2 заалт нь тухайн жилийн төсөв, төсвийн тодотголыг хэлэлцэн батлах тухай заалт бөгөөд энэхүү заалтыг зөрчиж тодотгол хийгээгүй болно.
ЗӨВЛӨМЖ:		
1	<i>Монгол улсын төсөвт</i> Монгол улсын төсөвт хийсэн тодотголд үндэслэн аймгийн орон нутгийн төсөвт тодотголыг хийж Аймгийн ИТХ-аар батлуулж байх.	Монгол улсын "Төсвийн тухай" хуулийн 34.2.1-д "Дээд шатны төсөвт тодотгол хийсний улмаас тухайн шатны төсөвт тодотгол хийх зайлшгүй шаардлага бий болсон" тохиолдолд Засаг дарга төсвийн тодотголыг боловсруулж тухайн шатны иргэдийн төлөөлөгчдийн хуралдаанд өргөн мэдүүлнэ" мөн хуулийн 57,3-т "Орон нутгийн төсвийн урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэх зарлагыг төсөвт тусган баталж хэрэгжүүлэх ба зарлага нь санхүүжүүлэх эх үүсвэрээс хэтрэхгүй байна." гэж тус тус заасан нь 2014 оны орон нутгийн төсвийн тодотголын төслийг боловсруулах үндэслэл болж байна. -Урьд оны давсан орлого, дансны үлдэгдлийг Төсвийн тодотгол хийх замаар л зарцуулах эрх үүснэ. Давсан орлого, дансны үлдэгдлийг орон нутгийн хөрөнгө оруулалт болон зайлшгүй шаардлагатай эх үүсвэрт хуваарилан зарцуулах нь Аймаг, сумын ИТХ-ын бүрэн эрх юм. Энэхүү хөрөнгийг тодотгол хийлгүйгээр дансандаа хадгалаад байх нь төсвийн хөрөнгийн үр ашиггүй байдлыг бий болгоно.
2	Аймгийн Аудитын газраас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн орон	Аудитын газрын өгсөн зөвлөмж, орон нутгийн орлогын бүтэц бүрдүүлэлтэнд судалгаа, шинжилгээ хийн үзсэний үр дүнд орон нутгийн мал эмнэлэг, ариун цэврийн гарал үүслийн гэрчилгээ олголтын тусгай зөвшөөрлийн тэмдэгтийн хураамжийн орлогоос 12642,0 мянган төгрөгийг, Мөрөн суманд үйл

	нутгийн орлого, зарлагыг бодитой төлөвлөх	ажиллагаа явуулан ус ашиглаж байгаа 20 ААНБ, иргэдээс 2014 онд нийт 944,0 мянган төгрөг, төвлөрсөн шугаманд холбогдсон 100 орчим ААНБ-уудаас 3500,0 мянган төгрөгийг ус ашиглуулах гэрчилгээнд олгох улсын тэмдэгтийн хураамжийн орлогоос оруулахаар, цалин хөлс түүнтэй адилтгах орлогын албан татвараас 158600,0 мянган төгрөгөөр, үл хөдлөх хөрөнгийн албан татвараас 100,000,0 мянган төгрөгөөр, газрын төлбөрийн орлогоос 30,000,0 мянган төгрөгөөр, хувьцааны ногдол ашгийн орлогоос 100,000,0 мянган төгрөгөөр нийт 405,686,0 мянган төгрөгийг орон нутгийн орлогод нэмж төлөвлөсөн болно				
		Сүүлийн 3 жилээр орон нутгийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл				
					/мян.төг/	
		Онууд	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Орлого давалт	Орлого давалт хувиар
		2012 он	6193.5	7148.8	955.3	115.4
		2013 он	7267.3	8695.1	1233.3	117.0
		2014 он	8606.3	9238.9	632.6	107.4
		Орон нутгийн орлого 2014 онд 8606,3 мянган төгрөгийн төлөвлөгөөтэйгээс 9238,9 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй, 632,6 мянган төгрөг буюу 107,4 хувиар орлого давж биелсэн байна.				
		Орон нутгийн орлого давахад ихээхэн нөлөөлсөн орлогуудыг авч үзвэл:				
		1. -Үйл ажиллагааны орлого 218,1 сая төгрөгөөр давсан нь арьс ширний урамшуулал 2014 онд шинээр олгогдсон ба төлөвлөлт хийх үед арьс ширний урамшууллыг яаж олгох, эсэх нь тодорхойгүй байсан тул төлөвлөгөөнд тусгагдаагүй.				
		2. -Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого 45,4 сая төгрөгөөр давж биелсэн ба 2014 онд ахуйн зориулалтаар бор гөрөөс, зэрлэг гахай, загас зэрэг ан амьтныг агнах барих зөвшөөрөл БОАЖЯ-аас олгохгүй гэж байсан боловч 7-р сард зөвшөөрөл олгосон, мөн Хэнх суманд загас агнуурын тэмцээн зохион байгуулж 6600,0 мянган төгрөг орсон. Тусгай зориулалтаар барих тул загасны тос 100 ширхэгээр тооцож байсан бол компаниудын хүсэлтээр 100 ширхэгээр нэмж олгосон зэрэг шалтгааны улмаас агнуураас орох орлого давж биелсэн.				
		3. -Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэсний төлбөрийн орлого: Аймгийн хэмжээнд Ойгоос хэрэглээний мод түлээ бэлтгэж ашигласны төлбөрөөс 653,5 сая төгрөг орохоос 741,6 сая төгрөгийн гүйцэтгэлтэй 88,1 сая төгрөгөөр давж биелсэн байна.				
		4. МУ-ын Засгийн газрын 2014 оны 9 дүгээр сарын 18-ны				

		өдрийн 307 дугаар “Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” тогтоолоор ойгоос бэлтгэсэн хэрэглээний болон түлээний модны үнэ өссөн. 5. Үг тогтоолыг аймгийн хэмжээнд 11 дүгээр сарын 06-наас хойш мөрдөж ажилласанаараа ойгоос орох хэрэглээний мод түлээ бэлтгэж ашигласны төлбөр 88,1 төгрөгөөр давхад нөлөөлсөн гэж үзэж байна. 6. Татварын бусын бусад орлого: Аймгийн татварын бусад орлогод 79,5 сая төгрөгийн төлөвлөгөөгүй гүйцэтгэл орж ирсэн ба энэ нь Аймгийн Аудитын газрын аудитын үйлчилгээ үзүүлсний төлбөрийн орлого бүртгэгддэг ба энэ төлбөрийн орлого нь ҮАГ-зарт шилжих тул орон нутгийн орлогын төлөвлөгөөнд тусгаадахгүй гүйцэтгэлд нь тусгагдсан нь орлогын давалтанд тодорхой хэмжээгээр нөлөөлж байна. Орон нутгийн орлого давалтанд дээр дурдэгдсан шалтгаанууд зайлшгүй нөлөөлсөн болохыг анхаарч үзнэ үү.
3.	Аймгийн орон нутгийн төсвийн гүйцэтгэлд дүн шинжилгээ хийж байх	2014 оны орон нутгийн орлогод бүтцийн, зэрэгцүүлсэн, харьцуулсан шинжилгээ хийж нийт 17 хуудас материал, төсвийн зарлагын шинжилгээний нийт 18 хуудас материалыг хүргүүлсэн болно. Төсвийн гүйцэтгэлийн шинжилгээг зохих түвшинд хийсэн гэж үзэж байна.

Жич: Тайланд Засгийн газрын баталсан орлого, ЗГ-ын баталсан төсөв, ЗГ-ын хянаснаар тооцвол гэсэн үг удаа дараа давтагдан гарч байгааг анхаарах. Төсвийг ЗГ-ын тогтоол биш УИХ-ын тогтоолоор баталдаг. Мөн УИХ-аас орон нутгийн төсвийн суурь орлогын доод хязгаарыг ирүүлдэг бөгөөд нэмэгдүүлэн батлах эрх нь Аймгийн ИТХ-ын хуралдаанд байдаг болно.

Хянасан: Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Г.Сувд
 Тайлбар бичсэн: CTCX-ийн ахлах мэргэжилтэн Х.Энхтуяа
 Мэргэжилтэн Г.Базар

ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН САНАЛ ӨГӨХ ТАЙЛБАР

АЗДТГ-ын Санхүү,Төрийн сангийн хэлтэс

Санал	Саналд өгөх тайлбар
1.Гүйцэтгэл гараагүй, огт биелээгүй орлого байхгүй байна. Орлого тасрахад орон нутгийн байгууллага, татварын байгууллагын үйл ажиллагаанаас хамааралгүй орлого тасрах шалтгаан байна.	Орлого тасарсан талаар холбогдох байгууллага, эрх бүхий албан тушаалтнуудыг буруутгаагүй болно.Иймд тайланд өөрчлөлт хийх шаардлагагүй.
2.Аудитын газрын зөвлөмж, тооцоо судалгаанд үндэслэн ОНО-ыг 405,7 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталсан нь Төсвийн тогтвортой байдлыг хангаж ажиллж байгаа гэж үзэж байна.	Жилийн дундуур төсвийн орлогод тодотгол хийж байгаа нь Төсвийн турхай хуулийн 6.2.5 заалт “Төсвийн жилийн дундуур орлого бууруулах, зарлага нэмэгдүүлэх үр дагавартай бодлогын аливаа шийдвэр гаргасан бол түүнийг дараагийн төсвийн жилээс хэрэгжүүлдэг байх” гэсэн заалттай төдийлөн уялдахгүй байна. Тухайлбал: Үл хөдлөх хэрэнгийн албан татвар, ОНӨҮГ-ын ноогдол ашиг, ЦХТАОАТ зэрэг байна. Иймд саналыг хүлээн авах боломжгүй .
3.Нийт пүнгээрээ орон тоо хэтрээгүй. Зөвхөн гүйцэтгэх, үйлчлэх, гэрээтийн орон тоонууд дотор хөдөлсөн. Гүйцэтгэх ажилтан 41-ээр, үйлчилгээний ажилтан 65-аар тус тус хэтэрсэн боловч гэрээт ажилтан 106 дутуу ажилласан. Орон нутгийн байгууллагууд төлөвлөгөөний дагуу ажилласан ба харин хэтэрсэн, дутсан гэх орон тоо нь ТЗШ-ийн байгууллагууд сургууль, цэцэрлэгийн орон тоо юм.	Төсвийн турхай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.2-д “ Хуулийн 61.1-д заасан төлөөлөн хэрэгжүүлэх чиг үүргийг энэ хуулийн 39 дүгээр зүйлд заасан гэрээний үндсэн дээр улсын төсвөөс олгох тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжүүлнэ” гэж заасан тул АТЕЗ нь хэтэрсэн орон тооны асуудлын талаар чиг үүргийг хэрэгжүүлнэ. Саналыг хүлээн авах боломжгүй.
4.Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалын 3.1.4, 5.3 дахь заалтад заасан бүрэн эрхийн дагуу улиралд 1 удаа зохицуулалт хийх эрхтэй байдаг. Энэ журмынхаа дагуу Аймгийн засаг дарга 2014 онд 4 удаагийн зохицуулалтыг хийсэн. Төсвийн тодотголыг 2014 онд 1 удаа хийсэн. АИТХ-ын 2014 оны 6 дугаар сарын өдрийн хуралдааны 05 дугаар тогтоолоор 1 удаа төсвийн тодотгол хийсэн.	Аймгийн засаг даргын 2014 оны 12 дугаар сарын 24-ний А/461 тоот захирамжаар Халамжийн сангийн зардалд 20911,4 мянган төгрөгийн өөрчлөлт хийсэн нь Төсвийн турхай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.2 заалтыг зөрчсөн байна гэж аудитаар үзэж байна. Иймд саналыг хүлээн авах боломжгүй. Цаашид Төсвийн турхай хуулийн 4.1.8 заалтыг хэрэгжүүлж Сангийн яамнаас хянаж ирүүлсэн зарлагын дээд хязгаарыг баримтлан орон нутгийн төсвийн зардлыг нэмэгдүүлэхгүй байх зарчмыг анхаарч ажиллана уу.
5.ТЕЗ өөрийн хамаарах төсөвт Төсвийн турхай хуулийн 14.2.3, 14.2.5, 42.2.1, 42.2.2, 42.3.4, 42.5, Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалын 3.1.4, 5.3 дахь заалтад заагдсан бүрэн эрхийнхээ хүрээнд зохицуулалтыг хийж төсвийн байгууллагуудын хэвийн үйл ажиллагааг хангаж ажилласан.	Төсвийн ерөнхийлөн захирагч Төсвийн турхай хуулийн 42.2.1 а,б, в,г, 42.2.2, 42.2.3 заалтад хамааралтай өөрчлөлт нь төсвийн зохицуулалт болно. Харин тус хуулийн 34 дүгээр зүйлд заасантай холбогдуулан хийж байгаа өөрчлөлт нь төсвийн тодотголд хамааралтай. Иймд засаг даргын А/461 тоот захирамжаар хийгдэж байгаа өөрчлөлтүүд нь төсвийн тодотгол юм
Зөвлөмж	

Урьд оны давсан орлого, дансны үлдэгдлийг Төсвийн тодотгол хийх замаар л зарцуулах эрх үүснэ. Давсан орлого болон зайлшгүй шаардлагатай эх үүсвэрт хуваарилан зарцуулах нь Аймаг, сумын ИТХ-ын бүрэн эрх юм. Энэхүү хөрөнгийг тодотгол хийлгүйгээр дансандаа хадгалаад байх нь төсвийн хөрөнгийн үр ашиггүй байдлыг бий болгоно.	Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2 заалтад тодорхой заасан. Дээд шатны төсөвт тодотгол хийсний улмаас гэж өөрчлөв
ОНО, төсвийн зарлагыг бодитой төлөвлөхгүй байна гэдэг үндэслэлээ бодит байдалд нийцүүлэн дүгнэлт гаргана уу.	Сангийн яаманд хүргүүлсэн төсвийн санал, гүйцэтгэлд тулгуурлан Аудитын газраас жил бүрийн төсвийн төсөлд санал хүргүүлэн ажиллаж байна.
Төсвийн гүйцэтгэлийн шинжилгээг зохих түвшинд хийсэн гэж үзэж байна.	Төсвийн гүйцэтгэлийн шинжилгээнд тулгуурлан төсвийн санал боловсруулж байх